

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Мөнгөн хараа дуу, бүжгийн чуулгын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/164-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> <a href="#">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhuyach@audit.gov.mn">enkhuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayaro@audit.gov.mn">ankhbayaro@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4.АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Албан шаардлага .....	17
5.2 Зөвлөмж .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН МӨНГӨН ХАРАА  
ДУУ БҮЖГИЙН ЧУУЛГЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Л.МӨНХНАРАН ТАНАА

2024.02.20 № 00А-2024/188-НА-СТА-Т043  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 33.2 хувиар нэмэгдсэн байна.

Соёлын сайдын 2023 оны А/390 дугаар тушаалаар баталсан “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ын дагуу тайлант онд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр 44,561.5 мянган төгрөг хүлээн авч, зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Мөнгөн Хараа дуу бүжгийн чуулга нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн

018020023

захирагчийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа бөгөөд уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны харьяа гүйцэтгэлээр санхүүжиж буй байгууллагын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Мандал сумын Мөнгөн Хараа дуу бүжгийн чуулга нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 7 бүлэг 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 95.0 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>221,513,478.21</b>	<b>252,670,310.41</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>38,750,903.21</b>	<b>75,076,823.41</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>38,750,903.21</b>	<b>75,076,823.41</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>38,750,903.21</b>	<b>75,076,823.41</b>
31211	Төрийн сангийн харилцах	38,750,903.21	75,076,823.41
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>182,762,575.00</b>	<b>177,593,487.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>182,762,575.00</b>	<b>177,593,487.00</b>
35410	Бичиг хэргийн материал	146,200.00	266,200.00
35420	Аж ахуйн материал	27,314,107.00	19,635,277.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	2,691,000.00
35450	Барилгын засварын материал	4,607,600.00	5,016,600.00
35470	Бусад хангамжийн материал	150,694,668.00	149,984,410.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,279,823,628.29</b>	<b>1,208,052,903.48</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,279,823,628.29</b>	<b>1,208,052,903.48</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,177,023,628.17</b>	<b>1,105,752,903.32</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,143,232,200.00	1,143,232,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-111,645,601.51	-137,165,814.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,440,000.00	89,440,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62,159,999.92	-89,439,999.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	215,138,324.33	237,479,844.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-155,330,498.06	-189,470,989.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,767,426.00	21,767,426.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,313,278.88	-14,145,420.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	71,864,613.56	71,864,613.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	-24,969,557.35	-27,808,956.61
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>102,800,000.12</b>	<b>102,300,000.16</b>
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-999,999.88	-1,499,999.84
39303	Бусад биет бус хөрөнгө	102,300,000.00	102,300,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,501,337,106.50</b>	<b>1,460,723,213.89</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,501,337,106.50</b>	<b>1,460,753,213.89</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,501,337,106.50</b>	<b>1,460,723,213.89</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,143,543,879.70	1,143,543,879.70
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,143,543,879.70	1,143,543,879.70
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-297,996,364.13</b>	<b>-338,610,256.74</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,799,333,470.63	-297,996,364.13
51220	Тайлант үеийн үр дүн	1,501,337,106.50	-40,613,892.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	655,789,590.93	655,789,590.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,501,337,106.50</b>	<b>1,460,723,213.89</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,402,397,720.61</b>	<b>1,130,429,277.67</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,576,234,247.79</b>	<b>29,894,622.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,576,234,247.79</b>	<b>29,894,622.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>26,510,800.00</b>	<b>20,250,200.00</b>

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,510,800.00	20,250,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,377,839,752.79	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	171,883,695.00	9,644,422.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>826,163,472.82</b>	<b>1,100,534,655.67</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>643,237,900.00</b>	<b>935,520,044.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	643,237,900.00	935,520,044.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>182,925,572.82</b>	<b>165,014,611.67</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182,925,572.82	165,014,611.67
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>901,060,614.11</b>	<b>1,171,043,170.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>901,060,614.11</b>	<b>1,171,043,170.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>900,292,614.11</b>	<b>1,088,923,236.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>475,304,671.43</b>	<b>670,867,760.07</b>
210101	Үндсэн цалин	330,585,888.35	471,106,109.76
210102	Нэмэгдэл	84,875,077.70	125,852,677.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	27,991,138.74
210104	Урамшуулал	30,962,498.38	37,084,246.65
210105	Гэрээт ажлын хөлс	28,881,207.00	8,833,587.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,243,359.96</b>	<b>84,838,979.73</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,699,369.04	57,574,809.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,427,856.38	6,845,500.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,114,312.44	5,476,460.33
210204	Ажилгүйдлийн даатгал	797,186.37	1,355,894.22
210205	Эрүүл мэндийн даатгал	9,204,635.73	13,586,315.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>88,779,145.22</b>	<b>123,068,481.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,462,126.72	11,233,479.20
210302	Түлш, халаалт	81,941,614.50	102,545,975.47
210303	Цэвэр, бохир ус	2,375,404.00	3,289,027.00
210304	Байрны түрээс	0.00	6,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,380,080.00</b>	<b>19,513,880.00</b>
210401	Бичиг хэрэг	740,720.00	1,681,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,369,060.00	1,596,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	680,300.00	1,215,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	275,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	440,000.00	189,600.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	14,555,680.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>537,550.00</b>	<b>3,783,930.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	537,550.00	3,783,930.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>86,356,883.00</b>	<b>34,200,130.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	58,100.00
210604	Урсгал засвар	86,356,883.00	34,142,030.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>526,800.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	526,800.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>49,870,700.00</b>	<b>41,253,550.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,870,700.00	41,088,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	165,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>135,293,424.50</b>	<b>111,396,524.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,457,400.00	17,284,280.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,836,024.50	94,112,244.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>768,000.00</b>	<b>82,119,934.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>768,000.00</b>	<b>82,119,934.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	82,119,934.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,501,337,106.50</b>	<b>-40,613,892.61</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,501,337,106.50</b>	<b>-40,613,892.61</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>852,674,272.82</b>	<b>1,120,784,855.67</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>26,510,800.00</b>	<b>20,250,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>26,510,800.00</b>	<b>20,250,200.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>26,510,800.00</b>	<b>20,250,200.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,510,800.00	20,250,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>826,163,472.82</b>	<b>1,100,534,655.67</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>643,237,900.00</b>	<b>935,520,044.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	643,237,900.00	935,520,044.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>182,925,572.82</b>	<b>165,014,611.67</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182,925,572.82	165,014,611.67
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>813,103,469.61</b>	<b>1,062,117,415.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>813,103,469.61</b>	<b>1,062,117,415.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>812,335,469.61</b>	<b>979,997,481.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>475,304,671.43</b>	<b>670,859,460.07</b>
210101	Үндсэн цалин	337,899,704.35	471,097,809.76
210102	Нэмэгдэл	79,818,017.70	125,852,677.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	27,991,138.74
210104	Урамшуулал	30,962,498.38	37,468,329.77
210105	Гэрээт ажлын хөлс	26,624,451.00	8,449,504.04
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,243,359.96</b>	<b>84,838,979.73</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,699,365.66	57,574,809.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,427,856.38	6,845,500.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,114,315.44	5,476,460.33
210204	Ажилгүйдлийн даатгал	876,291.74	1,355,894.22
210205	Эрүүл мэндийн даатгал	9,125,530.74	13,586,315.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>88,779,145.22</b>	<b>123,068,481.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,583,312.72	11,233,479.20
210302	Түлш, халаалт	76,820,428.50	102,545,975.47
210303	Цэвэр, бохир ус	2,375,404.00	3,289,027.00
210304	Байрны түрээс	0.00	6,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,739,860.00</b>	<b>4,794,700.00</b>
210401	Бичиг хэрэг	540,500.00	1,292,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,369,060.00	1,596,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	680,300.00	1,380,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	250,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,275,300.00</b>	<b>0.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,275,300.00	0.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>89,061,233.00</b>	<b>43,089,630.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,143,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,491,200.00	0.00
210604	Урсгал засвар	86,570,033.00	41,946,130.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>526,800.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	526,800.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>51,571,300.00</b>	<b>38,919,350.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,571,300.00	38,754,350.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	165,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,833,800.00</b>	<b>14,426,880.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,833,800.00	14,426,880.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>768,000.00</b>	<b>82,119,934.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>768,000.00</b>	<b>82,119,934.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	82,119,934.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>39,570,803.21</b>	<b>58,667,440.20</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>819,900.00</b>	<b>22,341,520.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>819,900.00</b>	<b>22,341,520.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>819,900.00</b>	<b>22,341,520.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	819,900.00	22,341,520.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-819,900.00</b>	<b>-22,341,520.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>38,750,903.21</b>	<b>36,325,920.20</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	38,750,903.21
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,750,903.21	75,076,823.41

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-1,799,333,470.63	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,501,337,106.50	1,501,337,106.50
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-297,996,364.13	1,501,337,106.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-297,996,364.13	1,501,337,106.50
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-40,613,892.61	-40,613,892.61
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-338,610,256.74	1,460,723,213.89

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,168,907,400.00</b>	<b>1,084,458,935.47</b>	<b>-84,448,464.53</b>	<b>92.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,168,907,400.00</b>	<b>1,084,458,935.47</b>	<b>-84,448,464.53</b>	<b>92.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,082,090,600.00</b>	<b>1,002,339,001.47</b>	<b>-79,751,598.53</b>	<b>92.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>737,679,700.00</b>	<b>670,859,460.07</b>	<b>-66,820,239.93</b>	<b>90.94</b>
210101	Үндсэн цалин	492,776,000.00	471,097,809.76	-21,678,190.24	95.60
210102	Нэмэгдэл	136,074,300.00	125,852,677.76	-10,221,622.24	92.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,024,000.00	27,991,138.74	-7,032,861.26	79.92
210104	Урамшуулал	68,005,400.00	37,468,329.77	-30,537,070.23	55.10
210105	Гэрээт ажлын хөлс	5,800,000.00	8,449,504.04	2,649,504.04	145.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>92,209,900.00</b>	<b>84,838,979.73</b>	<b>-7,370,920.27</b>	<b>92.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	62,825,400.00	57,574,809.74	-5,250,590.26	91.64
210202	Тэтгэмжийн даатгал	7,346,000.00	6,845,500.42	-500,499.58	93.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,877,200.00	5,476,460.33	-400,739.67	93.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,469,300.00	1,355,894.22	-113,405.78	92.28
210205	Эрүүл мэндийн даатгал	14,692,000.00	13,586,315.02	-1,105,684.98	92.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>124,194,700.00</b>	<b>123,068,481.67</b>	<b>-1,126,218.33</b>	<b>99.09</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,536,700.00	11,233,479.20	1,696,779.20	117.79
210302	Түлш, халаалт	102,658,000.00	102,545,975.47	-112,024.53	99.89
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	3,289,027.00	-2,710,973.00	54.82
210304	Байрны түрээс	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,100,000.00</b>	<b>4,794,700.00</b>	<b>-1,305,300.00</b>	<b>78.60</b>
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,292,600.00	-307,400.00	80.79
210402	Тээвэр, шатахуун	3,200,000.00	1,596,800.00	-1,603,200.00	49.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	1,380,300.00	580,300.00	172.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	275,000.00	275,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	250,000.00	-250,000.00	50.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>63,371,400.00</b>	<b>63,370,650.00</b>	<b>-750.00</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,424,600.00	21,424,520.00	-80.00	100.00
210604	Урсгал засвар	41,946,800.00	41,946,130.00	-670.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>44,048,500.00</b>	<b>40,979,850.00</b>	<b>-3,068,650.00</b>	<b>93.03</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,368,500.00	40,814,850.00	-2,553,650.00	94.11
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	680,000.00	165,000.00	-515,000.00	24.26

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,486,400.00</b>	<b>14,426,880.00</b>	<b>-59,520.00</b>	<b>99.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,486,400.00	14,426,880.00	-59,520.00	99.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>86,816,800.00</b>	<b>82,119,934.00</b>	<b>-4,696,866.00</b>	<b>94.59</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>86,816,800.00</b>	<b>82,119,934.00</b>	<b>-4,696,866.00</b>	<b>94.59</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	85,816,800.00	82,119,934.00	-3,696,866.00	95.69
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	0.00	-1,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,168,907,400.00</b>	<b>1,120,784,855.67</b>	<b>-48,122,544.33</b>	<b>95.88</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>935,519,900.00</b>	<b>935,520,044.00</b>	<b>144.00</b>	<b>100.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	935,519,900.00	935,520,044.00	144.00	100.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>166,141,500.00</b>	<b>165,014,611.67</b>	<b>-1,126,888.33</b>	<b>99.32</b>
320001	Орон нутгийн төсвөөс	166,141,500.00	165,014,611.67	-1,126,888.33	99.32
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>67,246,000.00</b>	<b>20,250,200.00</b>	<b>-46,995,800.00</b>	<b>30.11</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,463,200.00	20,250,200.00	-1,213,000.00	94.35
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,695,000.00	0.00	-7,695,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,087,800.00	0.00	-38,087,800.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	38,750,903.21	38,750,903.21	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	75,076,823.41	75,076,823.41	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>83</b>	<b>83</b>	<b>0</b>	<b>100</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>41</b>	<b>41</b>	<b>0</b>	<b>100</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41	0	100
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>41</b>	<b>41</b>	<b>0</b>	<b>100</b>
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	32	32	0	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	0	100

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга /цаашид Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга/ нь “Нийгмийн баялгийг чанартай бүтээн туурвиж, ард иргэдийн оюунд соёлын хөрөнгө оруулалт хийж хөгжүүлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Соёл урлагийн олон талт үзвэр үйлчилгээгээр ард иргэдийг соён гэгээрүүлэх,
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх,
- Чанартай, хүртээмжтэй уран бүтээл туурвих.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Соёлын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-нд өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын онцлогт тохироогүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,613.9 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	38,750.9	75,076.8	36,325.9
Бараа материал	182,762.6	177,593.5	-5,169.1
Үндсэн хөрөнгө	1,279,823.6	1,208,052.9	-71,770.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,501,337.1</b>	<b>1,460,723.2</b>	<b>-40,613.9</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,501,337.1	1,460,723.2	-40,613.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,501,337.1</b>	<b>1,460,723.2</b>	<b>-40,613.9</b>

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 75,076.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь гүйцэтгэлээр санхүүжиж, төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,208,052.9 мянган төгрөг болж 71,770.7 мянган төгрөгөөр буурсан нь 22,341.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон тайлант онд 94,112.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 813,592.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 91,321.5 мянган төгрөг, нийт зарлагыг 904,913.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн. Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 32,873.2 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 28,446.8 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 19,865 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 98,869.7 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 18,297.5 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 7,920.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 2,100.0 мянган төгрөгөөр,
- Томилолт зочны зардлыг 1,640.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 4,000.0 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 46,950.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт **806,320.9** мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 362,586.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 242,675.7 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 30,334.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 21,424.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 13,486.4 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 86,816.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн/ нийт **1,168,907.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 935,519.9 мянган төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 166,141.5 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 21,463.2 мянган төгрөг,
- Туслах үйл ажиллагааны орлогоос 7,695.0 мянган төгрөг,
- Өмнөх оны үлдэгдлээс 38,087.8 мянган төгрөг гэх мэт.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр дараах 1,159,535.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Улсын төсвөөс 935,520.0 мянган төгрөгийн,
- Орон нутгийн төсвөөс 165,014.6 мянган төгрөгийн санхүүжилт,

- Өмнөх оны үлдэгдлээс 38,750.9 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогоор 20,250.2 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,084,458.9 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 63,748.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	823,229.5	752,478.5	-70,751.0	91.4
2	Уран бүтээл хийлгэх	20,000.0	19,999.4	-0.6	100.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	85,816.8	82,119.9	-3,696.9	95.7
4	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	44,561.4	44,561.3	-0.1	100.0
5	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	29,158.2	20,285.2	-8,873.0	69.6
6	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	166,141.5	165,014.6	-1,126.9	99.3
	<b>Дүн</b>	<b>1,168,907.4</b>	<b>1,084,458.9</b>	<b>-84,448.5</b>	<b>92.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэн, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримт, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 901,060.6 мянган төгрөгөөс **1** хувиар буюу **9,010.6** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус ангийн батлагдсан төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,171,043.2 мянган төгрөгөөс **1** хувиар тооцон **11,710.4** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Байгууллагын бүх хэсгийн буюу өрөө тасалгааны гэрлүүдийг цахилгаан зарцуулалт бага хэрэглэдэг лед гэрлээр сольж шинэчилсэн,

- Чуулгын байрны халаалтыг гэрээний дагуу төлж нэмэлт цахилгаан халаагуур залгахгүйгээр дулаан алдалтыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан цонх, хаалгыг дулаалсан,
- Бичиг хэргийн зардлыг хэмнэж батлагдсан төсвийг хэтрүүлэлгүй зарцуулсан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 167 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

##### Хугацаа хоцроосон:

- Дараа жилийн төсвийн төслийг 1 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг 1 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 2 удаа.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	354.3	1	354.3	100.0
Албан шаардлага	2	1,218.8	2	1,218.8	100.0
Зөвлөмж	2	0.0	2	0.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>1,573.1</b>	<b>5</b>	<b>1,573.1</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **7,342.9** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Бараа материалын тодруулгад үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 4,089.4 мянган төгрөгийн орлогыг худалдаж авснаар бүртгэсэн,
- Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад 2,110.0 мянган төгрөгийн элэгдлийг дутуу илэрхийлсэн,
- Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад 1,143.5 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн,

Аудитаар нийт **46,785.2** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 6,684.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 40,101.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 зөвлөмж өглөө.

#### 5.1 Албан шаардлага

1. Тус байгууллагад хуваарилагдсан үр дүнд суурилсан санхүүжилтийн 15 хувь буюу **6,684.2** мянган төгрөгийг албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бус бараа материал худалдан авахад зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Соёлын сайдын 2023 оны А/390 дугаар тушаалаар баталсан “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ын 7.1.3 дахь “*Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 15%-ийг санхүүжүүлэх*”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэлт: Үр дүнд суурилсан санхүүжилтийг батлагдсан аргачлалын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Тус байгууллагад хуваарилсан үр дүнд суурилсан санхүүжилтийн **31,193.0** мянган төгрөгийг хамт олны хурлын шийдвэргүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Соёлын сайдын 2023 оны А/390 дугаар тушаалаар баталсан “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ын 7.2 дахь “*Үр дүнгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг хамт олны хурлын шийдвэр, бусад бичиг баримтыг үндэслэн төсвийн шууд захирагч шийдвэр гаргаж, санхүүжүүлнэ*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үр дүнгийн нэмэлт санхүүжилтийг хамт олны хурлын шийдвэрийг үндэслэн зарцуулж байх.

### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **85** нэр төрлийн хөрөнгийг /*Нийт хөрөнгийн 8.6 хувь*/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*”, УСНББОУС-ын 17.49 “... *дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай*” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

### **3. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт: Нэмэлт төсвийн / өөрийн орлогын / зарцуулалтын эрхийг орлогын гүйцэтгэлд үндэслэн тухай бүр бус оны эхэнд бөөн дүнгээр нээж байгаагаас шалтгаалан төсвийн гүйцэтгэлийн тайланд өөрийн орлогын төлөвлөгөөг **8,908.0** мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2013 оны 72 дугаар тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам”-ын 7.2.4 дэх заалтыг зөрчиж байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг холбогдох журамд заасны дагуу орлогын гүйцэтгэлд үндэслэн тухай бүр нээлгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>3</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын тодруулгад үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг худалдаж авснаар бүртгэсэн	1	4,089.4			1	4,089.4	1	4,089.4				
Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад элэгдлийг дутуу тооцоолсон	1	2,110.0			1	2,110.0	1	2,110.0				
Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад бараа материал бүртгэсэн	1	1,143.5			1	1,143.5	1	1,143.5				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>7,342.9</b>			<b>3</b>	<b>7,342.9</b>	<b>3</b>	<b>7,342.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тус байгууллагад хуваарилагдсан үр дүнд суурилсан санхүүжилтийн 15 хувийг албан	1	6,684.2			1	6,684.2							

хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бус бараа материал худалдан авахад зарцуулсан												
Тус байгууллагад хуваарилсан үр дүнд суурилсан санхүүжилтийг хамт олны хурлын шийдвэргүйгээр зарцуулсан	1	31,193.0					1	31,193.0				
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1						1					
Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг орлогын гүйцэтгэлд үндэслэлгүй илүү нээлгэсэн	1	8,908.0					1	8,908.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>46,785.2</b>			<b>1</b>	<b>6,684.2</b>	<b>3</b>	<b>40,101.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0.00							1	0.00		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0.00</b>							<b>1</b>	<b>0.00</b>		